



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны яамны 2022 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 343,855,567.5 (гурван зуун дөчин гурван сая найман зуун тавин таван мянга таван зуун жаран долоон төгрөг таван мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэнд төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт болон дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай;

2.1. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2 дахь заалтыг мөрдөж ажиллах;

2.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.2.2-т заасан үндсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дарга, гишүүдэд арга хэмжээ авах;

2.3. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.2. в-т заасан ёс зүйн хэм хэмжээ зөрчиж 59,547,980.00 (тавин есөн сая таван зуун дөчин долоон мянга есөн зуун наян) төгрөгийн балансын үнэ бүхий төрийн эд хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашиглаж буй албан хаагчдад тус дүрмийн 4.2-т заасан хариуцлага тооцож, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд тавих хяналтыг сайжруулах;

2.4. Засгийн газрын 3 дугаар байрны 4 давхар байрлах 31 м.кв талбай "кофе шоп-номын сан"-ийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар ашиглаж байгаа талбайг Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолын дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулж, түрээсийн төлбөрийн 40 хувийг зохих хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.5. Боловсрол, шинжлэх ухааны яамны нэр дээрх Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвгэрт байрлах 01119-2017/01200 газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаартай, 1980 м2 талбай бүхий газрыг барилга эзэмшигч байгууллагын нэр дээр шилжүүлэх, газар эзэмших эрхийг үнэлж бүртгэх;

2.6. Засгийн газрын 3 дугаар байрны 1 давхрын болон үүдний угтах үйлчилгээ, хүлээлгийн танхимын тохижилтын засварын дүнгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээ газар ТӨААТҮГ-т хандаж зохих шийдвэр гаргуулж, барилга байгууламжийн дансанд капиталжуулж, бүртгэх;

2.7. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, автотээврийн хэрэгслийн хувийн хэргийг хөтлөлт. баяжуулалтыг тухай бүр хийж ажиллах;

2.8. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй хөрөнгө, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу ангилан ялгаж дансны ангилал хооронд шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтэд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц. Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт



Боловсрол, шинжлэх ухааны яаманд
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төг.)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам зөрчсөн	-	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөх
2	Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэсэн зөрчил	284,307,587.5	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг мөрдөх
3	Албан хаагчдад гэрээр ашиглуулсан компьютер, тоног төхөөрөмжийн зөрчил	59,547,980.00	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 Дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам" -ыг мөрдөж, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчит бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах
НИЙТ ДҮН		343,855,567.5	(гурван зуун дөчин гурван сая найман зуун тавин таван мянга таван зуун жаран долоон төгрөг таван мөнгө)